



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/197

Булган сум

**Хушин ойн талбайд төлөв байдлын
судалгаа хийх эрх шилжүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хушин ойн талбайд төлөв байдлын судалгаа хийх (Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Бүрэгхангай, Бугат сум) төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах 20,000,000 (хорин сая) төгрөгийн эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын "Хушин ойн талбайд төлөв байдлын судалгаа хийх (Тэшиг, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Бүрэгхангай, Бугат сум)" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

